



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/46

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дахь заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөвсгөлд зочлох жил”-ийн хүрээнд зохион байгуулах “Цаа, цасны баяр-2023” өв соёлын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Даваадамдин (Соёл урлагийн газрын дарга)

Гишүүд:

Б.Батбилгүүн	(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Л.Бямбасүрэн	ОБГ-ын гамшгаас хамгаалах хяналтын улсын ахлах байцаагч)
Д.Идэрбат	(Хилийн 0257 дугаар ангийн хангалтын албаны дарга)
Б.Ганзориг	(Цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийн дарга)
Б.Банзрагч	(Хөгжимт драмын театрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Даваадорж	(БОАЖГ-ын мэргэжилтэн)
Ж.Төмөрсүх	(Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргааны дарга)
Б.Цэрэн-Очир	(Цагааннуур сумын Засаг дарга)
Д.Отгонбаяр	(Рэнчинлхүмбэ сумын Засаг дарга)
Н.Батбаяр	(Улаан-Уул сумын Засаг дарга)
С.Өлзийсайхан	(Духа төвийн тэргүүн)
Б.Бат-Эрдэнэ	(Уран барималч)
Б.Ганхөлөг	(Хөвсгөл Арт галерей)
Д.Рэгзэдмаа	(Аймгийн тогооч нарын холбоо)
М.Сарангэрэл	(Аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Л.Батцэцэг (СУХ-ийн дарга)

Захирамж-2023

6712010140

2.

2. “Цаа,цасны баяр-2023” өв соёлын наадмыг зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг хэсгийн ахлагч (Ж.Даваадамдин)-д, өв соёлын наадмыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж хамтран ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Өв соёлын наадам зохион байгуулахтай холбоотой зардлын тооцоог нарийвчлан гаргаж 2023 оны 02 сарын 08-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Даваадамдин)-д үүрэг болгосугай.

4. “Цаа, цасны баяр-2023” өв соёлын наадмыг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны тайланг 2023 оны 03 сарын 10-ны дотор гаргаж ирүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Л.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН